

Америк дахь “Sound essence” ТББ-ийнхан Монгол оюутнуудад тэтгэлэг олгож байна

Өнөөдөр дэлхийн зах зээл дээр магадгүй алт, нефть... инфляциас ч илүү үнэ нь хором хормоор өсөн нэмэгдэж байгаа зүйл бол “БОЛОВСРОЛ” болоод байгааг хэн хүнгүй мэднэ. Боловсрол гэдэг хүмүүний амьдралд хичнээн их хэрэгтэйг ухамсарласан Монгол хүн бүхэн өнөөдөр үр хүүхдүүдээ боломж бололцооныхоо хэрээр суралцуулахыг хичээх болжээ. Гэвч олонхи залуусын хувьд их дээд сургуульд суралцахад нь өндөр босго болдог “сургалтын төлбөр”-ийн бэрхшээлээс шалтгаалан боловсролтой болох хүсэл зорилгодоо хүрэхэд хүндхэн байгаа энэ үед зарим байгууллагуудаас оюутан залуучуудад боломж олгон “сургалтын тэтгэлэг” олгох буяны гараа сунгаж байгаа билээ.

Алс тэртээх хилийн чанд дахь АНУ – ын баруун эргийн Bellingham хэмээх жижиг хотоос мөн хэсэг сайн санаат хүмүүс сэтгэл гарган Монголын соёл, зан заншлийг олон улсад таниулах, монголын залуучуудад туслах зорилгоор “Sound Essence” төрийн бус байгууллагийг байгуулан, манай улсын иргэн Адилбишийн Солонго, Чулуунбаатарын Цоггэрэл, Батсайханы Баяржаргал, Отгонбаярын Оюуномин, Баянбатын Зулзаяа нарийн таван оюутанд бүтэн дөрвөн жилийн турш сургалтын тэтгэлэг олгон төгсгөсөн бөгөөд одоо ч оюутан Мижидийн Эрхэмбаяр, Ганаагийн Хулан, Сарнай нарт нэг хоёрдугаар дамжааных нь сургалтын төлбөрийн тэтгэлэгийг олгосоор байгаа юм.

Тэдний төлөөлөл болон Отгонбаярын Оюуномин хэлэхдээ :

“Би Дархан-Уул аймгийн ХААИС – ийн худалдааны менежментийн ангийг төгссөн. Одоо мэргэжилээрээ худалдааны байгууллагад ажиллаж байна. Уг тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах болсон нь ганц миний амьдралд ч биш, бидний залуучуудын амьдралд олдсон ховорхон аз завшаан гэж ойлгож, баярлаж явдаг. Тиймээс ч эх орныхоо хөгжилд тус нэмэр болох зүйлийг хийж бүтээхсэн хэмээн хичээн ажиллаж, амьдарч байна. Төслийнхөө ах эгч нартаа чин сэтгэлээсээ баярлаж явдагаа дахин дахин уламжля” гэлээ.

Уг төслийн монгол талын захирал хадагтай Чимэдрэгзэнгийн Болорцэцэг өгүүлэхдээ : “-Монголынхоо оюутнуудад зориулсан тэтгэмжийг хийх юмсан гэдэг бодол надад олон жилийн өмнөөс төрсөн юм. Тэгээд Америкд танилцсан найзуудтайгаа энэ саналаа хуваалцаж, улмаар тэдэнтэйгээ хамтран энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийг санаачлан тохироод 2005 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Залуу хүмүүст боловсрол олоход нь туслана гэдэг бол хамгийн том тус гэж ойлгодог. Та нэг хүнд оройн хоолоор туслалаа гэхэд, тэр хүн нэг хоног л гэдэс цатгалан явна. Харин та хэн нэгэн ухаантай, залуу хүнд боловсрол олоход нь туслах юм бол тэр хүний амьдралын туршид нь тус болж байгаа хэрэг шүү дээ” гэж ярьсан юм.

Энэхүү “Sound Essence” байгууллагын Ерөнхий захирал хадагтай Susan Bradbury болон хадагтай Ч.Болорцэцэг нарын санаачлагаар өмнө нь тус ТББ-аас Монгол ардын үлгэр домгийн арвин их сан хөмрөгөөс олон улсад сурталчлах зорилгоор “Туульч” - төсөл, жижиг дунд бизнесийг дэмжих чиглэлээр “Нарийн боовны үйлдвэрлэл” төсөл, байгаль хамгаалах чиглэлээр Эрдэнэт хотод “Мод тарих” төсөл мөн 2006 онд “Хүүхдийн нүдээр энх тайван” сэдэвт олон улсын хүүхдийн гар зургийн үзэсгэлэнг зохион байгуулж байсан юм.